



## МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,  
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,  
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,  
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

2024.10.24 № 03/8803

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Гомдол хянасан тухай

“МОНГОЛЫН ИРГЭНИЙ  
АГААРЫН ТЭЭВЭР” ТӨХК-Д

СЭЖ Н. Чам  
ЧГЗ Б. Ганзориг нар  
Холбогдох зүйлийн 48 р  
зүйлийн дагуу дахин  
чиэлж  
Э/30

Танай байгууллагаас зарласан МИАТ/20240103122 дугаартай “Агаарын хөлгийн иж бүрэн даатгал”-ын үйлчилгээ үзүүлэгчийг сонгох тендер шалгаруулалтад оролцсон “Хаандаатгал” ХХК-аас гаргасан гомдлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн 59 дүгээр зүйлийн 59.8 дахь хэсэг болон Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-д заасны дагуу захиалагчаас ирүүлсэн холбогдох баримт материалд үндэслэн хянан үзлээ.

“Хаандаатгал” ХХК-ийн гомдолд тус компанийн тендерээс тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1.4-т заасан шаардлага хангаагүй гэж татгалзсан захиалагчийн шийдвэрийг зөвшөөрөхгүй, мөн захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон “Бодьдаатгал” ХК-ийн ирүүлсэн тендер нь тендерийн шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 16.1.2, ТШЗ 19.1.А, ТШЗ 19.1.1-д заасан шаардлага, гэрээний тусгай нөхцөлийн сэлбэг хэрэгслийн үнэлгээ, гуравдагч этгээдийн өмнө хүлээх хариуцлагын даатгалын үнэлгээтэй холбогдох шаардлага тус тус хангахгүй байх тул хянан үзэхийг хүссэн байна.

I. “Хаандаатгал” ХХК-ийн гомдолд дурдсан үндэслэлээр захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон “Бодьдаатгал” ХК-ийн тендерийг хянан үзлээ.

1. Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 16.1.2-т “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолтыг цахим хэлбэрээр авна. /Шүүхийн маргааны холбогдох шийдвэрүүдийг тендерт ирүүлнэ./ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт авах хүсэлтийг оролцогч худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д өөрийн үндэсний тоон гарын үсэг ашиглан тендерийн нээлтээс өмнө хүчин төгөлдөр тодорхойлолтыг цахим хэлбэрээр ирүүлнэ.” гэж заасан байна.

Сангийн сайдын 2023 оны А/248 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын 2.5-д заасны дагуу худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээс шалгахад “Бодьдаатгал” ХК нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны 2024 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн тодорхойлолт ирүүлснийг дээрх шаардлагад нийцсэн гэж хянан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлтэй байна.

9766016644

УЛААНБААТАР ХОТ  
МИАТ ТӨХК  
ТТМ № 2287

Бүртгэсэн № . . . карт № *1390*  
Он, сар, өдөр *2024.10.30*  
..... цаг ..... минут  
.....-д шилжүүлэв.  
Хуудасны тоо .....

*үз авчирч өгөв.*

Тендер шалгаруулалтын баримт бичигт шүүхийн тусгай архивын лавлагаа ирүүлэхийг шаардаагүй, мөн тус тендер шалгаруулалтыг 2024 оны 08 дугаар сарын 16-ны өдөр зарласан байх ба дээрх журмын 2.5-д зааснаар захиалагч тендер шалгаруулалт зарласнаас хойших мэдээллийг тендер хянан үзэхэд үндэслэл болгох тул “Бодьдаатгал” ХК тендерт шүүхийн тусгай архивын хариуцагчаар оролцож байсан тухай тодорхойлолт, шүүхийн маргааны холбогдох шийдвэрүүд ирүүлээгүй, тендерийн нээлтээс өмнө авсан тодорхойлолт ирүүлсэн нь тус тус шаардлага хангахгүй тухай “Хаандаатгал” ХХК-ийн гомдол үндэслэлгүй байна.

2.Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-ийн А)-д “МИАТ-ийг /MIAT account/ хариуцсан шийдвэр гаргах түвшний дотоодын даатгалын компанийн ажилтны дэлгэрэнгүй мэдээлэл /Маягт 10 дагуу ирүүлнэ/. Үүнд: Англи хэлний дундаас дээш түвшний мэдлэгтэй байх /Сертификатыг ТББ-д хавсарган ирүүлэх/” гэж заасан байна.

“Бодьдаатгал” ХК-ийн тендерт ирүүлсэн 2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 01/834 тоот албан бичигт “... ТШЗ 19.1-д заасан шаардлагын дагуу 24 цагийн турш яаралтай холбогдох, “МИАТ” ТӨХК-ийн Агаарын хөлгийн иж бүрэн даатгалыг хариуцан ажиллах дотоодын болон гадаадын мэргэжилтнүүдийн мэдээлэл: “Бодьдаатгал” ХК-ийн Давхар даатгалын хэлтсийн захирал Ч.Эгиймаа, “AON” давхар даатгалын брокерын ахлах мэргэжилтэн Алтинай Абдулин. Дэлгэрэнгүй мэдээллийг хавсаргав.” гэж дурдсан, тендерт Ч.Эгиймаагийн товч намтар, “Glasgow Caledonian University”-д суралцаж төгссөн талаарх магистрын зэргийн дипломын хуулбарыг орчуулгын хамт ирүүлсэн байх тул тус ажилтны англи хэлний дундаас дээш түвшний мэдлэгтэй байхыг нотлох сертификат ирүүлээгүй нь дээрх шаардлага хангахгүй тухай гомдол үндэслэлгүй байна.

3.Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1.1-д “Давхар даатгалын хувьд: 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Лондон, түүнтэй дүйцэхүйц олон улсын даатгалын зах зээлд Даатгуулагчийн агаарын хөлгийг 100% байршуулан холбогдох даатгалын гэрчилгээг гаргаж өгөх баталгаа бүхий давхар даатгалын Брокерын албан захидал, орчуулгын хамт ирүүлэх” гэж заасан байна.

“Бодьдаатгал” ХК тендерт 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 01/802 тоот “... ТШЗ 19.1-д заасан шаардлагын дагуу “Агаарын хөлгийн иж бүрэн даатгал”-ын гэрээ байгуулах тухай албан ёсны хариу ирүүлснээс хойш 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор багтаан Лондон, түүнтэй дүйцэхүйц олон улсын даатгалын зах зээлд даатгуулагчийн агаарын хөлгийг 100% байршуулан, холбогдох гэрээний эх хувь, даатгалын сертификатыг 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн дотор гаргаж өгөх бөгөөд энэ хугацаанд гаргаж өгөөгүй тохиолдолд түүнээс үүдэн гарах хохирол /нислэг саатах, үүнээс үүдэн гарах бусад зардал, хохирол/-ыг даатгуулагчид бүрэн төлж барагдуулахаа энэхүү албан тоот баталгаажуулж байна.” гэж дурдсан давхар даатгалын гэрчилгээг гаргаж өгөх тухай албан бичиг, мөн “AON” компанийн 2024 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн “Бид “МИАТ” ТӨХК-ийн 2024 оны Агаарын хөлгийн иж бүрэн даатгалын тендерийн шаардлагын дагуу 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс өмнө агаарын хөлгийн иж бүрэн даатгалыг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үнэлгээний агентын зэрэглэл бүхий Лондон болон түүнтэй дүйцэхүйц олон улсын зах зээл дээр 100% байршуулан, давхар даатгалын гэрээнүүдийн эх хувь болон сертификатуудыг 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс өмнө хүргүүлэхээ үүгээр баталгаажуулж байна.” гэж дурдсан албан бичиг тус тус ирүүлснийг дээрх шаардлагад нийцсэн гэж хянан үзсэн нь үндэслэлтэй байна.

Тендер шалгаруулалтын баримт бичгийн гэрээний тусгай нөхцөлийн нэмэлт нөхцөл, давхар даатгалын 5-д “Даатгагч нь даатгалын болон давхар даатгалын сертификатыг 2024 оны 11 дүгээр сарын 20-ны дотор гаргаж өгөх бөгөөд энэ хугацаанд гаргаж өгөөгүй тохиолдолд түүнээс үүдэн гарах хохирол /нислэг саатах, үүнээс үүдэн гарах бусад зардал, хохирол/-ыг даатгуулагчид бүрэн төлж барагдуулна.” гэж заасан байгааг дурдах нь зүйтэй байна.

4.Тендер шалгаруулалтын баримт бичгийн гэрээний тусгай нөхцөлийн даатгалын үнэлгээ хэсэгт “сэлбэг хэрэгслийн үнэлгээ: 50,000,000.0 ам.доллар, гуравдагч этгээдийн өмнө хүлээх хариуцлагын даатгалын үнэлгээ: Boeing 767-300ER (JU-1021, EI-MGL, EI-UBN) - 1,000,000,000.0 ам.доллар, Boeing 757 (JU-1109, JU-1015, EI-MNG, JU-1088) - 750,000,000.0 ам доллар, Boeing 737-800 (EI-CXV) - 600,000,000.0 ам.доллар, CRJ 700 (JU-1700) - 300,000,000.0 ам.доллар” гэж заасан байна.

“Бодьдаатгал” ХК-ийн тендерт ирүүлсэн маягт №1-ээр тендер шалгаруулалтын баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон болохоо баталгаажуулсан, мөн тендерт “Давхар даатгалын гэрээ” (агаарын хөлгийн их бие /сэлбэг хэрэгсэл, тоног төхөөрөмж/, хариуцлага, нисэх багийн гэнэтийн ослын давхар даатгал) хавсаргасан байна.

Дээрх гэрээний үнэлгээ (их бие) хэсэгт “Хавсралт дахь агаарын хөлгийн мэдүүлгээр баталгаажсан үнэлгээ: Нэг агаарын хөлгийн дээд үнэлгээ 175,000,000.0 ам.доллар байна. Сэлбэг хэрэгсэл болон тоног төхөөрөмж: Нэг удаагийн болон нийт нөхөн төлбөрийн дээд хязгаар 50,000,000.0 ам.доллар байна.” гэж, хариуцлага: Даатгуулагчийн бусдын эд хөрөнгө (үүнд ачаа тээшний мэдүүлсэн үнэ), амь нас, эрүүл мэндэд учруулсан хохирлын өмнө хүлээх нийт хариуцлагын дээд хязгаар нь 1,000,000,000.0 ам.доллар ба доорх дэд хязгааруудтай байна: i).B737-800 (EI-CXV-ээс бусад), B377-Max8 болон B757 агаарын хөлгийн хувьд: Нэг удаагийн тохиолдлын нийт хязгаар 750,000,000.0 ам.доллар; ii).B737-800 бүртгэлийн дугаар EI-CXV: нэг удаагийн тохиолдлын нийт хязгаар 600,000,000.0 ам.доллар; iii).CRJ700 агаарын хөлгийн хувьд нэг удаагийн тохиолдлын нийт хязгаар 300,000,000.0 ам.доллар байна.” гэж заасан байна.

Гомдолд “Бодьдаатгал” ХК-ийн давхар даатгалын слип гэрээ болон түүний орчуулга дээр “Нэг удаагийн тохиолдлоос үүдэлтэй нэг эсхүл хэд хэдэн нэхэмжлэхийн дээд хязгаар 10,000 ам.доллар байна” гэж, “Тээш, хувийн эд зүйл нэг удаагийн нэхэмжлэх дээд хязгаар 1,250.0 ам.доллар, ачаа тээш нэг удаагийн агаарын тээврийн төлбөрт 10,000.0 ам.доллар байна” гэж тусгасан бөгөөд захиалагч “нэг удаагийн тохиолдолтой холбоотой олгох нөхөн төлбөрийн дээд хязгаар зааж өгөөгүй тул шаардлага хангахгүй” талаар дурдсан байх тул дээрх асуудлыг Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-ын 5.9-д зааснаар нягталж үзэх нь зүйтэй байна.

II.Гомдолд дурдсан үндэслэлээр “Хаандаатгал” ХХК-ийн тендерээс татгалзсан захиалагчийн шийдвэрийг хянан үзлээ.

Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1.4-т “Давхар даатгалын хувьд: Ангарын болон газрын үйлчилгээний хариуцлагын үүний

Налтсан  
үзэх

1. ...  
 2. ...  
 3. ...  
 4. ...  
 5. ...  
 6. ...  
 7. ...  
 8. ...  
 9. ...  
 10. ...  
 11. ...  
 12. ...  
 13. ...  
 14. ...  
 15. ...  
 16. ...  
 17. ...  
 18. ...  
 19. ...  
 20. ...  
 21. ...  
 22. ...  
 23. ...  
 24. ...  
 25. ...  
 26. ...  
 27. ...  
 28. ...  
 29. ...  
 30. ...  
 31. ...  
 32. ...  
 33. ...  
 34. ...  
 35. ...  
 36. ...  
 37. ...  
 38. ...  
 39. ...  
 40. ...  
 41. ...  
 42. ...  
 43. ...  
 44. ...  
 45. ...  
 46. ...  
 47. ...  
 48. ...  
 49. ...  
 50. ...  
 51. ...  
 52. ...  
 53. ...  
 54. ...  
 55. ...  
 56. ...  
 57. ...  
 58. ...  
 59. ...  
 60. ...  
 61. ...  
 62. ...  
 63. ...  
 64. ...  
 65. ...  
 66. ...  
 67. ...  
 68. ...  
 69. ...  
 70. ...  
 71. ...  
 72. ...  
 73. ...  
 74. ...  
 75. ...  
 76. ...  
 77. ...  
 78. ...  
 79. ...  
 80. ...  
 81. ...  
 82. ...  
 83. ...  
 84. ...  
 85. ...  
 86. ...  
 87. ...  
 88. ...  
 89. ...  
 90. ...  
 91. ...  
 92. ...  
 93. ...  
 94. ...  
 95. ...  
 96. ...  
 97. ...  
 98. ...  
 99. ...  
 100. ...

101. ...  
 102. ...  
 103. ...  
 104. ...  
 105. ...  
 106. ...  
 107. ...  
 108. ...  
 109. ...  
 110. ...  
 111. ...  
 112. ...  
 113. ...  
 114. ...  
 115. ...  
 116. ...  
 117. ...  
 118. ...  
 119. ...  
 120. ...  
 121. ...  
 122. ...  
 123. ...  
 124. ...  
 125. ...  
 126. ...  
 127. ...  
 128. ...  
 129. ...  
 130. ...  
 131. ...  
 132. ...  
 133. ...  
 134. ...  
 135. ...  
 136. ...  
 137. ...  
 138. ...  
 139. ...  
 140. ...  
 141. ...  
 142. ...  
 143. ...  
 144. ...  
 145. ...  
 146. ...  
 147. ...  
 148. ...  
 149. ...  
 150. ...  
 151. ...  
 152. ...  
 153. ...  
 154. ...  
 155. ...  
 156. ...  
 157. ...  
 158. ...  
 159. ...  
 160. ...  
 161. ...  
 162. ...  
 163. ...  
 164. ...  
 165. ...  
 166. ...  
 167. ...  
 168. ...  
 169. ...  
 170. ...  
 171. ...  
 172. ...  
 173. ...  
 174. ...  
 175. ...  
 176. ...  
 177. ...  
 178. ...  
 179. ...  
 180. ...  
 181. ...  
 182. ...  
 183. ...  
 184. ...  
 185. ...  
 186. ...  
 187. ...  
 188. ...  
 189. ...  
 190. ...  
 191. ...  
 192. ...  
 193. ...  
 194. ...  
 195. ...  
 196. ...  
 197. ...  
 198. ...  
 199. ...  
 200. ...

дотор Даатгуулагч гэрээний үндсэн дээр гуравдагч этгээдийн агаарын хөлөгт үзүүлж буй газрын болон засвар үйлчилгээнээс гуравдагч этгээдэд учирч болзошгүй хохирлыг хариуцах даатгалд хамруулсан байх” гэж заасан байна.

“Хаандаатгал” ХХК-ийн тендерт ирүүлсэн “МИАТ” ТӨХК-ийн агаарын хөлгийн иж бүрэн даатгалын гэрээний даатгалын зүйл хэсэг (405 дахь хуудас)-ийн 7-д “Ангарын болон газрын үйлчилгээний хариуцлагын үүний дотор Даатгуулагч гэрээний үндсэн дээр гуравдагч этгээдийн агаарын хөлөгт үзүүлж буй газрын үйлчилгээ болон засвар үйлчилгээнээс гуравдагч этгээдэд учирч болох хохирол” гэж, хавсралт №1: Даатгалын үнэлгээ /ам.доллар/ (415 дахь хуудас)-д “Даатгуулагч гуравдагч этгээдийн агаарын хөлөгт үзүүлж буй газрын үйлчилгээ болон засвар үйлчилгээнээс гуравдагч этгээдэд учирч болзошгүй хариуцлагын даатгал” гэж тус тус заасан, мөн тендерт хавсаргасан “WTW” компанийн 2024 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн албан бичигт “... Манай хамтарсан баг дараах зүйлсийг амлаж байна. Үүнд: -“МИАТ” компанийн 2024-2025 оны ... гуравдагч этгээдийн өмнө хүлээх хариуцлагын даатгалын (даатгуулагч гуравдагч этгээдийн агаарын хөлөгт үзүүлж буй газрын үйлчилгээ болон засвар үйлчилгээнээс гуравдагч этгээдэд учирч болзошгүй хохирлын хариуцлагын даатгал мөн орно) хураамжийг 2,900,000.0 ам доллар буюу Монголбанкны 2024 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн ханшаар тооцон 9,802,000,000.0 төгрөг байлгах” гэж дурдсан байна.

Түүнчлэн гомдолд “тендерт хавсаргасан гэрээний төсөл (418 дахь хуудас)-ийн 6.2-т “Гуравдагч этгээдийн агаарын хөлөгт үзүүлж буй газрын үйлчилгээ болон засвар үйлчилгээнээс гуравдагч этгээдэд учирч болзошгүй хохирлын хариуцлагын хувьд: Нэг удаагийн тохиолдлын нийт хязгаар 25,000,000.0 ам.доллар” гэдэг нь нийт даатгалын үнэлгээ, тодруулбал тус гэрээний төслийн 415 дахь хуудас дахь даатгалын үнэлгээ/хавсралт №1-д заасан нийт даатгалын үнэлгээнээс давсан хохирлын хэсэгт нэмэлтээр 25,000,000.0 ам.долларыг хамгаална гэх санааг агуулж буй болно.” гэж дурдсан, мөн уг гэрээний төслийн 5.3-т “Агаарын тээврийн хариуцлага /Хэсэг 3/: Нисэхийн бус хариуцлагын ANV 59 (Non-Aviation liability clause AVN 59)-ийн хязгаарлалтын дагуу даатгуулагчийн агаарын тээврийн үйл ажиллагааны үүсэх хариуцлага” гэж заасан байгаа ба ANV 59 (Non-Aviation liability clause AVN 59) хязгаарлалт нь олон улсын стандарт нөхцөл бөгөөд үүнд даатгуулагчийн бусдад бараа бүтээгдэхүүн нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой үүсэх эрсдэлүүд хамаардаг” талаар дурдсан байх тул дээрх асуудлыг шаардлагад нийцсэн эсэхийг нягталж үзэх нь зүйтэй байна.

Иймд хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.1 дэх заалтыг үндэслэн захиалагчийн 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 01/2501 тоот шийдвэрийг хүчингүй болгон шийдвэрлэж байна.

Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.2 дахь заалтад үндэслэн тендер шалгаруулалтын тендерийн хянан үзэх, үнэлэх ажиллагааг хуульд нийцүүлэн дахин хийхийг мэдэгдье.

Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.7 дахь хэсэгт заасны дагуу захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг түдгэлзүүлсэн шийдвэрийн хугацаа үүгээр дуусгавар болно.

Хувийг: “Хаандаатгал” ХХК-д.

ТӨРИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Ж.ГАНБАТ

